

**АВТО ЗАМЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Авто замын бодлого зохицуулалтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримталсан.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Тус газраас 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 7 төрлийн үүрэг даалгаврын хүрээнд 399 арга хэмжээг хэрэгжүүлсэн ба тэдгээрийн биелэлтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүнг үзүүлсэн.

2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

№	Бүтээгдэхүүн	Ажил, үйлчилгээний тоо	Хэрэгжилтийн ангилал					Хэрэгжилтийн дүн (Хувь)
			Үр дүнтэй буюу 100 хувь	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хүртэл хувь	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувь	Үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувь	Үнэлгээнд оруулаагүй	
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	176	104	24	9	18	21	83.1

2.2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилт:

№	Нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн ангилал					Хэрэгжилтийн дүн (Хувь)
		Үр дүнтэй буюу 100 хувь	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хүртэл хувь	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувь	Үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувь	Үнэлгээнд оруулаагүй	
1	18	7	1	2	8	-	80.2



2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

№	Эрх зүйн актын нэр	Нийт арга хэмжээ /заалт/	Үүнээс хэрэгжилт хувиар						Биелэлт /хувиар/
			100	70	30	0	Хугацаа болоогүй	Хяналтаас хассан	
1	УИХ-ын тогтоол	3	1	2	-	-	-	-	80
2	УИХ-ын байнгын хорооны тогтоол	1	1	-	-	-	-	-	100
3	Засгийн газрын тогтоол	25	16	7	-	-	2	-	90.87
4	Ерөнхий сайдын захирамж	-	-	-	-	-	-	-	-
5	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	31	23	8	-	-	-	-	92.3
6	Засгийн газрын албан даалгавар	13	1	7	5	-	-	-	56.9
Нийт		73	42	24	5	-	2	-	84.9

2.4. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт:

№	Нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн ангилал					Хэрэгжилтийн дүн (Хувь)
		Үр дүнтэй буюу 100 хувь	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хүртэл хувь	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувь	Үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувь	Үнэлгээнд оруулаагүй	
1	32	11	1	-	20	-	55.4

2.5. Зам, тээврийн Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс хэрэгжилтийн хувиар					Хүчингүй болсон	Биелэлт хувь
	100	70	30	0	Хугацаа болоогүй		
38	15	17	6	-	-	-	75.33

2.6. Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс хэрэгжилтийн хувиар						Биелэлт /хувиар /
	100%	70%	30%	Тасарсан	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
55	24	17	6	2	-	6	76.94

2.7. Зам, тээврийн хөгжлийн Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

№	Хариуцах байгууллага, газар, хэлтэс	Төлөвлөсөн нийт арга хэмжээ	Үнэлгээ, хувиар							Хувь
			100	90	70	50	30	0	Үнэлгээнд оруулаагүй, хугацаа болоогүй	
1	АЗБЗГ	7	-	3	1	-	-	1	2	68.0

Гурав. Дүгнэлт

1. Тус газраас 2024 оны жилийн эцсийн байдлаар 7 төрлийн үүрэг даалгаврын хүрээнд 399 арга хэмжээний биелэлтийг ирүүлж, тэдгээрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 203, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хүртэл хувийн хэрэгжилттэй 88, эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувийн хэрэгжилттэй 11, үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 68 (үүнээс тасарсан 13), хугацаа болоогүй 2, хүчингүй болсон 6, үнэлгээнд оруулаагүй 23 арга хэмжээ байна. Нийт хэрэгжилт нь 77.9 хувьтай байна.

2. Тус газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 176 арга хэмжээний биелэлтийг цаасаар боловсруулж, нэгжийн дарга нь баталгаажуулж ирүүлсэнийг хянахад 63 арга хэмжээний биелэлтийг алдаатай бичсэн, 10 арга хэмжээ (2.40, 2.45, 2.108, 2.113, 5.3, 5.10, 5.11, 6.3, 6.8, 6.14 дугаартай арга хэмжээ)-ний хувьд биелэлтээ шинэчлээгүй буюу өнгөрсөн улирлуудад ирүүлсэн биелэлтээ давтан ирүүлсэн зэрэг алдаа, зөрчил гаргасан байна.

3. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн 2 арга хэмжээ (80, 90 дугаартай арга хэмжээ)-ний биелэлтийг тус газраас огт ирүүлээгүй байна.

4. Тус газрын үйл ажиллагаанаас үл хамаарах 7 шалтгаанаар хэрэгжээгүй 21 арга хэмжээ байна. Үүнд:

Шалтгаан 1: Нутгийн ард иргэдээс Цагаандэл боомтыг нээх, авто зам барихыг эсэргүүцсэн хэвээр байгаатай холбоотой 1 арга хэмжээ (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.7 дахь арга хэмжээ);

Шалтгаан 2: Өмнөх гүйцэтгэгчийн шүүхийн маргаан үргэлжилж байгаа болон маргаан гарсантай холбоотой 2 арга хэмжээ (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.94, 2.95 дахь арга хэмжээ);

Шалтгаан 3: Нийслэлд эрх нь шилжсэн болон Нийслэлийн ЗДТГ болон Нийслэлийн газрын албанаас авто зам барих газрыг чөлөөлөхтэй холбоотойгоор ажлын зурагт өөрчлөлт хийгдэж байгаатай холбоотой 1 арга хэмжээ (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.99 дэх арга хэмжээ);

Шалтгаан 4: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу концессын гэрээ байгуулагдаагүй, гарын үсэг зурагдаагүй, санхүүжилт нь батлагдаагүйгээс төслүүдийг цааш үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн мөн санхүүжилтийг Монгол Улсын 2025 оны Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн, гэрээ цуцлагдсантай зэрэгтэй холбоотой 5 арга хэмжээ нь: (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.8, 4.9, 4.10, 4.11, 4.12 дахь арга хэмжээ);

Шалтгаан 5: Зам барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан ч санал ирүүлсэн оролцогч байгаагүй тул хүчингүй болсон, тендерийг дахин зарласан, үргэлжилж байгаа 2 арга хэмжээ (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.110, 2.113 дахь арга хэмжээ);

Шалтгаан 6: Зам барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж одоогоор тендерийн материал хүлээн авч байгаа, тендерийг нээх хугацаа болоогүй, тендерийг үнэлж байгаа, тендер шалгаруулалт оны сүүлчээр дууссан зэрэгтэй холбоотой 9 арга хэмжээ (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.5, 2.13, 2.16, 2.17, 2.18, 2.19, 2.33, 2.43, 2.54 дэх арга хэмжээ) тус тус байна.

Шалтгаан 7: Зам барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичигт санхүүжүүлэгч Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас зөвшөөрөл авахаар хүргүүлсэн 1 арга хэмжээ (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.11 дэх арга хэмжээ) тус тус байна.

5. Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хурлын үеэр тус газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаагаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн зөвлөмж хэсэгт тусгуулахаар хэлсэн 7 саналын хувьд:

✓ Саналын 1, 3, 4, 5, 6-д тусгагдсан асуудлууд нь аудитын шалгалт түүнээс өгөх зөвлөмжтэй холбоотой бөгөөд энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар тэдгээр ажлуудад санал, зөвлөмж хүргүүлэх боломжгүй;

✓ Саналын 7-д тусгагдсан асуудлын хувьд тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ тус бүрээр буюу нийт 176 заалт бүхий санал, зөвлөмж боловсруулах боломжгүй юм. Харин гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 176 арга хэмжээтэй холбоотой нийтлэг асуудлуудын хувьд санал, зөвлөмж боловсруулсан;

✓ Саналын 2-т тусгагдсан 7 авто замын барилгын ажлын явцын биелэлт нь тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 арга хэмжээний 4 дүгээр улирлын биелэлттэй хамт манай газарт ирсэн бөгөөд тэдгээрт хяналт-шинжилгээ хийж, арга хэмжээ тус бүрд үнэлгээ өгөгдсөн. Харин дээрх 7 авто замтай холбоотойгоор тусдаа санал, зөвлөмж гарахгүй;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Тус газраас 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 176 арга хэмжээнээс тасарсан 15 арга хэмжээ, үр дүнгүй буюу 1-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн ч бүрэн дуусгаж чадаагүй 31-69 хүртэл хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусган, ажлыг эрчимжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2. Тус газрын үйл ажиллагаанаас үл хамаарах 7 шалтгаанаар хэрэгжээгүй 21 арга хэмжээг үнэлгээнд оруулахгүй байх;

3. Дээрх 21 арга хэмжээг 2025 онд хэрэгжих боломжтой, боломжгүйгээр ангилж, хэрэгжих боломжгүй арга хэмжээнүүдийг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгахгүй байх;

4. Дүгнэлт хэсгийн 2, 3-т дурдсан байдлаар алдаа, зөрчил гаргасан тус нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авах;

5. Цаашид биелэлтийн тайлан ирүүлэхдээ биелэлтэд тавигдах шаардлагуудыг мөрдөж биелэлтийг алдаагүй, тоо баримттай, үнэн зөв боловсруулж, хянан баталгаажуулж байх гэсэн санал, зөвлөмжийг тус тус хүргүүлж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР